

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/002/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 51-260512 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Ариунжаргал Утас:51-261628 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn Аудитор: Г.Өсөхжаргал Утас: 261885 Цахим хаяг: usukhjargalg@audit.gov.mn
-----------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА З.ЭНХБОЛД ТАНАА

2025.03.25 № 01/1217
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн еөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар харьяа байгууллагуудад дараах материаллаг хэмжээний зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

1. Нэмэлт санхүүжилтийн дансанд орсон дээд шатны төсвийн захирагчаас олгосон санхүүжилтийн 1,114.4 сая төгрөг, татаас санхүүжилтийн авлагын үлдэгдэл 36.4 сая төгрөгийг холбогдох байгууллага, нэгжтэй тус тус тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;
2. Бараа, ажил үйлчилгээнд зарцуулсан 162.0 сая төгрөгийг бараа материалын болон тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бүртгэсэн;
3. Тайлант онд ажилчдын цалин, урамшуулал, татвар, шимтгэлийг зөрүүтэй тооцсон зэрэг нийт 165.0 сая төгрөг;
4. Санхүүгийн тайланд тусгасан авлагын үлдэгдэл өмнөх оноос 123.0 сая төгрөгөөр нэмэгдсэн;
5. Үндсэн хөрөнгийн тооллогоор 59.2 сая төгрөгийн хөрөнгө дутагдсан, 17.0 сая төгрөгийн бараа материалын тооллого хийгээгүй;
6. Бараа худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулалгүй нийт 92.6 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн, батлагдсан төсвийг 71.8 сая төгрөгөөр зориулалт бусаар, үрэлгэн зарцуулсан зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт

дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 15.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “нийцсэн ба зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нэмэлт санхүүжилтээр Засаг даргын нөөц хөрөнгөөс төсвийн захирагчид хуваарилсан 4,759.6 сая төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлого 252.2 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс хуваарилсан 1,408.6 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 458.8 сая төгрөг, нийт 6,879.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, гүйцэтгэлээр 6,743.0 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 136.2 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь тайлант онд давхардсан тоогоор 353 байгууллагын ажлын байрны төлбөрийн буцаалтын материалыг хүлээн авч, шалган, шаардлага хангасан материалын дагуу ажлын байрны буцаалтад 6,710.8 сая төгрөгийг олгосон байна.

Бусад асуудал

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь Европын холбооны санхүүжилтээр НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр болон Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилтгүй уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих” төслийн хүрээнд гадаад улсад хөдөлмөрийн гэрээт ажилтнаар сонгогдсон иргэний хөдөлмөрлөх эрхийг хангах, албадан хөдөлмөр эрхлэлтээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийн ойлголт, мэдлэгийг сайжруулах зорилгоор “Явахын өмнөх бэлтгэл сургалтын гарын авлага” бэлтгүүлэх зардалд нийт 12.4 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 2 төрлийн 2,500 ширхэг гарын авлага хэвлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГ



Я.САМБУУНЯМ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		2,645,385.8	3,750,982.9
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	176,247.9	422,785.3
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	514,733.4	637,754.1
УРЬДЧИЛГАА	7а, 7б	32,600.0	19,464.1
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	1,921,804.5	2,670,979.3
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		55,456,848.1	58,143,763.2
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	55,456,848.1	58,143,763.2
Биет хөрөнгө		47,294,644.4	50,450,946.2
Биет бус хөрөнгө	13	8,162,203.6	7,692,817.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		58,102,233.8	61,894,746.1
НИЙТ ӨР ТӨЛБӨР		46,438.7	37,313.2
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	46,438.7	37,313.2
Өглөг	17а, 17б	46,438.7	37,313.2
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		58,055,795.2	61,857,432.8
Засгийн газрын хувь оролцоо		58,055,795.2	61,857,432.8
Засгийн газрын оруулсан капитал		15,932,240.6	16,278,018.0
Хуримтлагдсан үр дүн		35,253,453.1	38,815,199.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		6,870,101.6	6,764,215.9
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		58,102,233.8	61,894,746.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		64,006,016.1	92,488,158.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	11,532,171.2	12,439,770.3
Нийтлэг татварын бус орлого		11,532,171.2	12,439,770.3
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		52,473,844.9	80,048,388.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	60,739,435.8	88,124,080.4
УРСГАЛ ЗАРДАЛ		60,739,435.8	88,124,080.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		56,676,462.9	74,396,984.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		36,308,862.8	52,549,430.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		4,410,375.0	6,410,001.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		2,964,899.4	3,190,816.4
Хангамж, бараа материалын зардал		1,559,701.9	1,472,218.8
Нормативт зардал		1,824,423.3	2,105,010.7
Эд хогшил, урсгал засварын зардал		373,365.5	614,190.1
Томилолт, зочны зардал		278,589.1	292,065.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,147,883.7	2,754,854.2
Бараа үйлчилгээний бусад зардал		5,808,362.2	5,008,397.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		4,062,972.9	13,727,096.2

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		3,266,580.3	4,364,078.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		67.3	1,394.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		437,012.5	1,059,684.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		2,829,635.1	3,305,787.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	56,356,114.3	85,822,659.4
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,874,677.4	5,759,396.8
Нийтлэг татварын бус орлого	3,874,677.4	5,759,396.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	52,481,436.9	80,063,262.5
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	56,072,799.4	84,713,162.2
УРСГАЛ ЗАРДАЛ	56,072,799.4	84,713,162.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,920,519.6	70,917,787.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,259,911.6	52,547,808.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,388,846.6	6,374,519.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,925,672.1	3,165,930.8
Хангамж, бараа материалын зардал	1,345,107.0	1,261,251.0
Нормативт зардал	1,765,948.8	2,721,555.0
Эд хогшил, урсгал засварын зардал	249,415.9	600,398.1
Томилолт, зочны зардал	272,187.2	292,425.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,445,080.5	3,179,780.2
Бараа үйлчилгээний бусад зардал	1,268,349.9	774,119.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,152,279.8	13,795,375.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	283,314.9	1,109,497.1
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	155,616.2	831,221.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	155,616.2	831,221.0
Дотоод эх үүсвэрээр	155,616.2	831,221.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(155,616.2)	(831,221.0)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(19,999.1)	(31,738.8)
Бусад эх үүсвэр	67.3	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	20,066.4	31,738.8
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	107,699.6	246,537.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	68,548.3	176,247.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	176,247.9	422,785.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	55,085,685.6	-	55,085,685.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	93,295.7	-	93,295.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	55,178,981.2	-	55,178,981.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(32,476.1)	-	(32,476.1)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	79,655.0	-	79,655.0
6	Тайлант үеийн үр дүн	2,829,635.1	-	2,829,635.1
7	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	58,055,795.2	-	58,055,795.2
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	266,777.7	-	266,777.7
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	58,322,572.9	-	58,322,572.9
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(105,885.7)	-	(105,885.7)
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	334,958.0	-	334,958.0
13	Тайлант үеийн үр дүн	3,305,692.6	-	3,305,787.6
14	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	61,857,337.8	-	61,857,432.8

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	75,697,680,800.00	71,346,747,066.51	4,350,933,733.49	94.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	75,697,680,800.00	71,346,747,066.51	4,350,933,733.49	94.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70,488,146,900.00	66,362,048,854.12	4,126,098,045.88	94.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	53,398,012,200.00	50,140,957,310.56	3,257,054,889.44	93.9
210101	Үндсэн цалин	27,275,217,600.00	26,652,499,257.34	622,718,342.66	97.7
210102	Нэмэгдэл	16,374,949,000.00	14,107,817,970.54	2,267,131,029.46	86.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,883,676,900.00	5,810,145,768.85	73,531,131.15	98.8
210104	Урамшуулал	3,864,168,700.00	3,569,431,053.83	294,737,646.17	92.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,555,866,400.00	6,096,225,596.46	459,640,803.54	93.0
210201	Тэтгэврийн даатгал	4,444,895,000.00	4,175,196,471.03	269,698,528.97	93.9
210202	Тэтгэмжийн даатгал	529,416,800.00	492,696,815.02	36,719,984.98	93.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	264,708,200.00	244,663,172.76	20,045,027.24	92.4
210204	Ажилгүйдлийн даатгал	264,709,900.00	232,450,989.83	32,258,910.17	87.8
210205	Эрүүл мэндийн даатгал	1,052,136,500.00	951,218,147.82	100,918,352.18	90.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,233,353,700.00	3,080,900,418.55	152,453,281.45	95.3
210301	Гэрэл, цахилгаан	599,840,700.00	545,009,010.20	54,831,689.80	90.9
210302	Түлш, халаалт	1,510,198,300.00	1,477,274,606.21	32,923,693.79	97.8
210303	Цэвэр, бохир ус	248,291,400.00	192,651,934.54	55,639,465.46	77.6
210304	Байрны түрээс	875,023,300.00	865,964,867.60	9,058,432.40	99.0
2104	Хангамж, бараа материалын зардал	906,551,100.00	877,447,457.07	29,103,642.93	96.8
210401	Бичиг хэрэг	242,950,300.00	239,691,518.35	3,258,781.65	98.7
210402	Тээвэр, шатахуун	210,727,300.00	194,602,216.14	16,125,083.86	92.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	110,594,100.00	100,389,182.38	10,204,917.62	90.8
210404	Ном, хэвлэл	600,000.00	50,000.00	550,000.00	8.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	29,357,500.00	25,946,520.00	3,410,980.00	88.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	312,321,900.00	316,768,020.20	(4,446,120.20)	101.4
2105	Нормативт зардал	2,690,136,300.00	2,592,463,558.70	97,672,741.30	96.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	195,891,500.00	195,431,059.24	460,440.76	99.8
210502	Хоол, хүнс	2,076,252,700.00	1,977,096,072.46	99,156,627.54	95.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	417,992,100.00	419,936,427.00	(1,944,327.00)	100.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,073,412,400.00	1,062,882,840.40	10,529,559.60	99.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	580,067,100.00	572,614,671.50	7,452,428.50	98.7
210602	Тавилга	8,729,900.00	10,490,000.00	(1,760,100.00)	120.2
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	88,421,100.00	87,160,784.00	1,260,316.00	98.6
210604	Урсгал засвар	396,194,300.00	392,617,384.90	3,576,915.10	99.1
2107	Томилолт, зочны зардал	254,053,600.00	239,434,900.24	14,618,699.76	94.2
210702	Дотоод албан томилолт	240,582,100.00	226,076,872.34	14,505,227.66	94.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	13,471,500.00	13,358,027.90	113,472.10	99.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,301,862,000.00	2,197,618,561.14	104,243,438.86	95.5

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,043,418,200.00	1,965,850,805.22	77,567,394.78	96.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	26,798,000.00	24,839,100.00	1,958,900.00	92.7
210803	Даатгалын үйлчилгээ	72,698,600.00	63,086,080.22	9,612,519.78	86.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	15,660,800.00	12,349,052.50	3,311,747.50	78.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,194,500.00	1,431,370.00	763,130.00	65.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	101,058,900.00	95,764,649.74	5,294,250.26	94.8
210807	Газрын төлбөр	33,104,500.00	28,819,441.00	4,285,059.00	87.1
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,165,300.00	1,728,062.46	1,437,237.54	54.6
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,763,200.00	3,750,000.00	13,200.00	99.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,899,200.00	74,118,211.00	780,989.00	99.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,700,000.00	29,700,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	45,199,200.00	44,418,211.00	780,989.00	98.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,209,533,900.00	4,984,698,212.39	224,835,687.61	95.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,209,533,900.00	4,984,698,212.39	224,835,687.61	95.7
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	94,663,700.00	94,663,700.00	-	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,060,300.00	26,060,234.08	65.92	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,094,430,100.00	885,247,473.69	209,182,626.31	80.9
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,859,020,100.00	3,846,167,552.62	12,852,547.38	99.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	135,359,700.00	132,559,252.00	2,800,448.00	97.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	75,697,680,800.00	71,672,452,019.06	4,025,228,780.94	94.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	73,368,705,200.00	69,173,701,168.13	4,195,004,031.87	94.3
310001	Улсын төсвөөс санхүүжих	73,368,705,200.00	69,173,701,168.13	4,195,004,031.87	94.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,328,975,600.00	2,498,750,850.93	(169,775,250.93)	107.3
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	673,263,200.00	679,412,066.24	(6,148,866.24)	100.9
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,655,712,400.00	1,819,338,784.69	(163,626,384.69)	109.9
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	34	34	-	100.0
610001	Төсвийн байгууллага	34	34	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,867	1,854	13	99.3
620001	Удирдах ажилтан	35	35	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	1,440	1,439	1	99.9
620003	Үйлчлэх ажилтан	392	380	12	96.9

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		6,879,227,852.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ		6,879,227,852.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,191,162,168.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,406,850,724.32
210101	Үндсэн цалин		396,576,648.17
210102	Нэмэгдэл		1,728,880,590.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт		32,901,000.00
210104	Урамшуулал		248,492,485.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		278,293,545.01
210201	Тэтгэврийн даатгал		218,824,217.99
210202	Тэтгэмжийн даатгал		14,866,742.11
210203	ҮОМШӨ-ний даатгал		9,179,871.69
210204	Ажилгүйдлийн даатгал		6,732,884.76
210205	Эрүүл мэндийн даатгал		28,689,828.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		85,030,373.67
210301	Гэрэл, цахилгаан		55,571,463.55
210302	Түлш, халаалт		27,302,527.62
210303	Цэвэр, бохир ус		2,156,382.50
2104	Хангамж, бараа материалын зардал		390,717,711.20
210401	Бичиг хэрэг		150,528,470.00
210402	Тээвэр, шатахуун		142,830,594.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		27,691,630.00
210404	Ном, хэвлэл		5,240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		64,427,017.00
2105	Нормативт зардал		133,391,454.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		11,680,164.80
210502	Хоол, хүнс		101,608,390.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		20,102,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		238,409,040.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		146,122,125.00
210602	Тавилга		27,730,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		14,800,000.00
210604	Урсгал засвар		49,756,915.00
2107	Томилолт, зочны зардал		56,990,200.00
210702	Дотоод албан томилолт		56,990,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,047,272,289.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,027,822,289.67
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		18,000,000.00
210807	Газрын төлбөр		1,450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		554,206,830.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		334,004,965.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		220,201,865.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,688,065,684.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,551,848,833.34
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		145,150,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		13,775,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		1,246,154,000.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		146,769,633.34
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		136,216,850.74
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		7,512,924.37
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		34,023,844.71
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг		94,680,081.66
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		6,879,227,852.75
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		6,879,227,852.75
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		252,161,160.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,759,617,432.03
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,408,615,346.72
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		458,833,914.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,956.6 сая төгрөгийн 86 алдаа¹ илэрснээс 43.1 сая төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт тогтоож, 396.8 сая төгрөгийн зөрчилд 19 албан шаардлага хүргүүлж, 440.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 40 зөвлөмж хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2,154.5 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,555.8 сая төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 35 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 30 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага түүврийн аудитад хамрагдаж, татан буугдсан 1 байгууллага аудитад хамрагдаагүй байна. Аудитад хамрагдсан байгууллагуудын 28 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 2 байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 3,919.2 сая төгрөгийн 83 алдааг залруулж, 880.7 сая төгрөгийн 69 зөрчил илрүүлээ.

5.Төсвийн төвлөрүүлэн захирагч:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 1,311.2 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 37.3 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 1,150.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 123.0 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

5.1 Албан шаардлага:

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын татаас санхүүжилтийн авлага 36.4 сая төгрөгийг дээд шатны байгууллагатай, нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны байгууллагаас хуваарилсан 1,114.4 сая төгрөгийг нийгмийн халамжийн сан хариуцсан албан тушаалтантай тус тус тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 35 байгууллагын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,799.9 сая төгрөгийн 150 алдаа, зөрчил илэрснээс 3,919.3 сая төгрөгийн 83 алдааг залруулга хийлгэж, залруулаагүй 880.7 сая төгрөгийн 67 зөрчил илэрсэн нь төсвийн төвлөрүүлэн захирагчаас санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-д "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;", Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтын үр дүнтэй хэрэгжүүлэн, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, зөрчлийг 20-оос доошгүй хувиар бууруулах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын дансны үлдэгдэлтэй холбоотой

Илрүүлэлт 1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар харьяа байгууллагуудын авлага өмнөх оноос 123.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 15 дугаар зүйлийн 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харьяа байгууллагуудын авлагыг барагдуулахад анхаарч шинээр авлага үүсгэхгүй төсвийг зохистой удирдах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 3,956.6 сая төгрөгийн 86 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	Байгууллагын нэрс	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
A	1	3=5+7	4=6+8	5	6	7	8	9	10	11	12	13=11	14=12
1	ХХҮЕГ-ТТЗ	3	37,356.8	1	7,580.9	2	29,775.9	3	37,356.8	-	-	-	-
	Дүн	3	37,356.8	1	7,580.9	2	29,775.9	3	37,356.8	0	0	0	0
Харьяа байгууллагууд-ТШЗ													
1	ХХҮЕГ /аппарат/	9	139,833.8	3	59,250.2	6	80,583.6	9	139,833.8	-	-	-	-
2	Ахмад настны үндэсний төв	6	624,332.0	3	534,855.3	3	89,476.7	6	624,332.0				
3	Баянгол дүүргийн ХХҮХ	1	55,178.0			1	55,178.0	1	55,178.0				
4	БЗД-ийн ХХҮХ	1	11,968.0			1	11,968.0	1	11,968.0				
5	Багахангай дүүргийн ХХҮХ	5	55,878.9			5	55,878.9	5	55,878.9				
6	Багануур дүүргийн ХХҮХ	2	29,916.9			2	29,916.9	2	29,916.9				
7	налайх дүүргийн ХХҮХ	7	17,655.5			7	17,655.5	7	17,655.5				
8	СХД ХХҮХ	3	315,777.2	1	70,623.9	2	245,153.3	3	315,777.2				
9	Сүхбаатар дүүргийн ХХҮХ	2	177,129.7	1	167,261.6	1	9,868.1	2	177,129.7				
10	Чингэлтэй дүүргийн ХХҮХ	7	631,112.4	5	232,406.9	2	398,705.5	7	631,112.4				
11	ХУД-ийн ХХҮХ	4	100,453.3			4	100,453.3	4	100,453.3				
12	Нийслэлийн ХХҮХ	3	415,700.8			3	415,700.8	3	415,700.8				
13	Баян-Өлгий аймгийн ХХҮГ	3	25,212.3	1	7,580.9	2	17,631.4	3	25,212.3				
14	Баянхонгор аймгийн ХХҮГ	1	15,480.0	1	15,480.0			1	15,480.0				

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

15	Булган ХХҮГ	1	191,749.9			1	191,749.9	1	191,749.9				
16	Говь-Алтай аймгийн ХХҮГ	2	12,261.7	1	11,634.9	1	626.8	2	12,261.7				
17	Говьсүмбэр аймгийн ХХҮГ	2	85,920.8			2	85,920.8	2	85,920.8				
18	Дархан-Уул аймгийн ХХҮГ	1	326,656.0			1	326,656.0	1	326,656.0				
19	Дорнод аймгийн ХХҮГ	1	3,351.5	1	3,351.5			1	3,351.5				
20	Дорноговь ХХҮГ	5	385,592.6			5	385,592.6	5	385,592.6				
21	Дундговь аймгийн ХХҮГ	1	1,063.2			1	1,063.2	1	1,063.2				
22	Завхан ХХҮГ	1	75,262.0	0	-	1	75,262.0	1	75,262.0	-	-	-	-
23	Өмнөговь аймгийн ХХҮГ	4	117,415.2	4	117,415.2			4	117,415.2	-	-	-	-
24	Ховд аймгийн ХХҮГ	4	13,005.2			4	13,005.2	4	13,005.2				
25	Хөвсгөл аймгийн ХХҮГ	1	80,046.9			1	80,046.9	1	80,046.9				
26	Увс аймгийн ХХҮГ	1	1,040.0	1	1,040.0			1	1,040.0	-	-	-	-
27	Сэлэнгэ ХХҮГ	2	6,799.8			2	6,799.8	2	6,799.8				
28	Төв аймгийн ХХҮГ	3	3,472.2	1	1,493.2	2	1,979.0	3	3,472.2				
	Дүн	83	3,919,265.8	23	1,222,393.6	60	2,696,872.2	83	3,919,265.8	-	-	-	-
	Нийт дүн	86	3,956,622.6	24	1,229,974.5	62	2,726,648.1	86	3,956,622.6	-	-	-	-

Аудитаар нийт 2,154.5 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 43.1 сая төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт тогтоож, 1,549.5 сая төгрөгийн зөрчилд 23 албан шаардлага хүргүүлж, 561.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 41 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэрс	Аудитын код	Аудитын дүгнэлт				Нийт зөрчил		Үүнээс					
			Үүнээс						Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Бүгд	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Түүвэрт	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ХХҮЕГ-ТТЗ	СНАГ-2025/024/НА-СТА-ТТЗ	1		1		3	1,273,795.1			2	1,150,774.4	1	123,020.7
	ДҮН					3	1,273,795.1		-	2	1,150,774.4	1	123,020.7	
1	ХХҮЕГ-Аппарат	СНАГ-2025/400/На-СТА-ТШЗ	1		1		10	283,793.4	1	4,581.0	5	178,162.3	4	101,050.1
2	Архангай аймгийн ХХҮГ	АРА-2025/2/НА-СТА-ТШЗ	1	1			2	3,443.8			2	3,443.8		
3	Баян-Өлгий аймгийн ХХҮГ	БӨА-2025/001/НА-СТА-ТШЗ	1			1	0	-						
4	Баянхонгор аймгийн ХХҮГ	БНА-2025/116/НА-СТА-ТШЗ	1	1			0	-						
5	Булган аймгийн ХХҮГ	БУА-2025/112/НА-СТА-ТШЗ	1	1			1	-					1	-
6	Говь-Алтай аймгийн ХХҮГ	ГАА-2025/076/НА-СТА-ТШЗ	1	1			1	15,835.0			1	15,835.0		
7	Говьсүмбэр аймгийн ХХҮГ	ГСА-2024/045/НА-СТА-ТШЗ	1	1			0	-						
8	Дархан-Уул аймгийн ХХҮГ	ДАА-2025/29/НА-СТА-ТШЗ	1	1			1	8,398.0					1	8,398.0
9	Дорноговь аймгийн ХХҮГ	ДГА-2025/96/НА-СТА-ТШЗ	1	1			1	-					1	-
10	Дорнод аймгийн ХХҮГ	ДОА-2025/048/НА-СТА-ТШЗ	1		1		5	107,454.3	2	23,968.3	3	83,486.0		
11	Дундговь аймгийн ХХҮГ	ДУА-2025/94/НА-СТА-ТШЗ	1	1			3	5,251.0	1	1,800.0	1	-	1	3,451.0
12	Завхан аймгийн ХХҮГ	ЗАА-2025/188/НА-СТА-ТШЗ	1	1			3	10,097.2					3	10,097.2
13	Орхон аймгийн ХХҮГ	ОРА-2025/066/НА-СТА-ТШЗ	1	1			2	9,445.0			1	1,933.0	1	7,512.0
14	Өвөрхангай аймгийн ХХҮГ	ӨВА-2025/044/НА-СТА-ТШЗ	1	1			3	5,172.3			1	1,365.0	2	3,807.3
15	Өмнөговь аймгийн ХХҮГ	ӨМА-2025/062/НА-СТА-ТШЗ	1	1			5	25,614.7			1	1,300.0	4	24,314.7
16	Сүхбаатар аймгийн ХХҮГ	СБА-2025/057/НА-СТА-ТШЗ	1	1			2	1,471.0			1	1,471.0	1	-
17	Сэлэнгэ аймгийн ХХҮГ	СЭА-2025/163/НА-СТА-ТШЗ	1	1			0	-						-
18	Төв аймгийн ХХҮГ	ТӨА-2025/079/НА-СТА-ТШЗ	1	1			2	11,601.4					2	11,601.4
19	Увс аймгийн ХХҮГ	УВА-2025/130/НА-СТА-ТШЗ	1	1			0	-						

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

20	Ховд аймгийн ХХҮГ	ХОА-2025/101/НА-СТА-ТШЗ	1	1			0	-						
21	Хөвсгөл аймгийн ХХҮГ	ХӨА-2025/110/НА-СТА-ТШЗ	1	1			4	23,650.2	1	3,076.9	1	20,007.7	2	565.6
22	Хэнтий аймгийн ХХҮГ	ХЭА-2025/038/НА-СТА-ТШЗ	1			1	1	8,399.9	1	8,399.9				
23	БГД-ийн ХХҮХ	НТАГ-2025/468/НА-СТА-ТШЗ	1	1	-		2	15,590.8			-	-	2	15,590.8
24	БЗД-ийн ХХҮХ	НТАГ-2025/652/НА-СТА-ТШЗ	1	1			4	5,374.4			1	-	3	5,374.4
25	БНД-ийн ХХҮХ	НТАГ-2025/465/НА-СТА-ТШЗ	1	1			0	-						
26	БХД-ийн ХХҮХ	НТАГ-2025/467/НА-СТА-ТШЗ	1	1			0	-						
27	Налайх дүүргийн ХХҮХ	НТАГ-2025/470/НА-СТА-ТШЗ	1	1			1	572.0					1	572.0
28	Нийслэлийн ХХҮХ	НТАГ-2025/655/НА-СТА-ТШЗ	1	1			4	18,082.0	1	391.2	1	16,811.5	2	879.3
29	СБД-ийн ХХҮХ	НТАГ-2025/537/НА-СТА-ТШЗ	1	1			1	13,773.8	-	-	-	-	1	13,773.8
30	Хан-Уул дүүргийн ХХҮГ	НТАГ-2025/473/НА-СТА-ТШЗ	1	1			1	6,750.0					1	6,750.0
31	Чингэлтэй дүүргийн ХХҮХ	НТАГ-2025/474/НА-СТА-ТШЗ	1	1			3	10,874.4					3	10,874.4
32	БНСУ дахь ХНХҮТ	СНАГ-2025/008/НА-СТА-ТШЗ	1			1	4	236,981.0			2	74,915.4	2	162,065.6
33	Япон улс дахь ХНХҮТ	СНАГ-2025/329/НА-СТА-ТШЗ	1			1	0	-						
34	Ор.ХХҮГ. Ахмадын сан		1			1	0	-						
35	Ахмад настны үндэсний төв	СНАГ-2025/010/НА-СТА-ТШЗ	1	1			3	53,121.2	1	901.2			2	52,220.0
	ТШЗ-дүн		35	28	2	5	69	880,746.8	8	43,118.5	21	398,730.7	40	438,897.6
	НИЙТ ДҮН						72	2,154,541.9	8	43,118.5	23	1,549,505.1	41	561,918.3

Нийцлийн асуудлаар нийт 1,845.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 1,481.7 сая төгрөгийн зөрчилд 15 албан шаардлага, 363.3 сая төгрөгийн зөрчилд 23 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Аймгийн нэрс	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ХХҮЕГ-ТТЗ	1	-			1	-		
	Дүн	1	-	-	-	1	-	-	-
1	ХХҮЕГ-Аппарат	5	55,500.4			4	47,467.9	1	8,032.5
5	Булган аймгийн ХХҮГ	1	-					1	-
6	Говь-Алтай аймгийн ХХҮГ	1	15,835.0			1	15,835.0		
7	Говьсүмбэр аймгийн ХХҮГ	2	49,982.4					2	49,982.4
15	Өмнөговь аймгийн ХХҮГ	4	3,299.4			4	3,299.4	-	-
17	Сэлэнгэ аймгийн ХХҮГ	2	-					2	-
18	Төв аймгийн ХХҮГ	1	-					1	-
21	Хөвсгөл аймгийн ХХҮГ	1	-					1	-
23	Багануур дүүргийн ХХҮХ	3	166,307.5			1	137,878.7	2	28,428.8
24	БГД-ийн ХХҮХ	1	10,141.0					1	10,141.0
25	БЗД-ийн ХХҮХ	3	1,120,524.9			1	1,106,856.9	2	13,668.0
26	Багахангай дүүргийн ХХҮХ	1	1,500.0					1	1,500.0
28	Налайх дүүргийн ХХҮХ	1	10,648.7					1	10,648.7
29	Нийслэлийн ХХҮХ	3	198,724.1			2	107,382.8	1	91,341.3
30	СХД-ийн ХХҮХ	1	26,900.0					1	26,900.0
31	СБД-ийн ХХҮХ	2	20,599.8					2	20,599.8
32	Хан-Уул дүүргийн ХХҮГ	3	105,146.4			1	63,051.2	2	42,095.2
33	Чингэлтэй дүүргийн ХХҮХ	2	60,001.2					2	60,001.2
	Харьяа байгууллагуудын дүн	37	1,845,110.8	-	-	14	1,481,771.9	23	363,338.9
	НИЙТ ДҮН	38	1,845,110.8	-	-	15	1,481,771.9	23	363,338.9